

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

Монгол Орны Газарзүй-Геоэкологи Сэтгүүл, англиар Mongolian Journal of Geography and Geocology бүтээлийн 45 дах дугаарыг уншигч та бүхний гарт хүргэж буйдаа баяртай байна. Тус эрдэм шинжилгээний бүтээлд физик газарзүй, нийгэм эдийн засгийн газарзүй, геоэкологийн салбар шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа, байгалийн нөөц, хүрээлэн буй орчин, технологи, инновац, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр, мэргэжлийн өндөр түвшинд туурвисан бүтээлүүдийг хэвлэн нийтэлдэг юм.

Бүтээлийн чанар, ач холбогдлыг өсгөх, олон улсын түвшний эрдэм шинжилгээний сэтгүүл болгох тал дээр хүрээлэнгийн эрдмийн зөвлөл, сэтгүүлийн редакцын зөвлөл онцгойлон анхаарч, 2017 оноос сэтгүүлийг хэвлэмэл хувилбараас гадна цахим (www.mjgg.igg.ac.mn) хэлбэрт шилжүүлж, 2019 онд ISSN дугаар авч, 2022 онд “Mongolia Journals Online”-д албан ёсны бүртгэлтэй болгож, мөн тус дугаараас эхэлж бүтээлийг DOI-оор дугаарлаж, Google Scholar, Dimensions системээс хайгдах хэлбэрт шилжүүлсэн болно. Ингэснээр зохиогчийн өгүүлэл зөвхөн манай улсын уншигчдад хүрэх бус олон улсын түвшинд жинхэнэ утгаараа гарч бусад орны эрдэмтэн судлаачдад ашиглах боломж олгох, бүтээлээс авах дотоод, гадаадын эшлэлийн тоог эрс нэмэгдүүлэх давуу талтай юм. Эдгээр нь манай хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын <https://www.researchgate.net/>, <https://orcid.org> цахим сангийн үзүүлэлтүүдээр илэрч байгаад талархалтай байна.

Энэ онд сэтгүүлийн чанарыг улам сайжруулах, олон улсын уншигчдад түгээх зорилгоор зарим өгүүллийг англи хэлээр хүлээн авч эхэллээ. Монгол Орны Газарзүй-Геоэкологи Сэтгүүлийн 45-р дугаарт 31 өгүүлэл хүлээн авснаас сэтгүүлийн шалгуурыг хангасан 20 өгүүллийг хэвлэж, эрхэм уншигч олон, эрдэмтэн судлаач та бүхэндээ хүргэж байна. Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн нэрийн хуудас болсон сэтгүүлийн энэ дугаарт эрдэм шинжилгээний өгүүлэл ирүүлсэн эрдэмтэн судлаачид, түүнийг хянан тохиолдуулсан редакторууд та бүхэнд бүтээлийг эрхлэх зөвлөлийн нэрийн өмнөөс болон хувиасаа талархал илэрхийлье.

Эрхэм баян эрдэм мэдлэг түгэн дэлгэрэх болтугай.

**Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн захирал,
сэтгүүлийн ерөнхий эрхлэгч, доктор А.Дашцэрэн**

<https://doi.org/10.5564/mjgg.v61i45.3753>

EDITORIAL MESSAGE

The 45th issue of the Mongolian Journal of Geography and Geoecology (MJGG) is now available to all readers. The MJGG publishes unpublished academic works in basic and applied research in physical geography, socioeconomic geography and geoecology; natural resources and environment; and development policy planning, technology, and innovation.

The Scientific Committee of the Institute of Geography and Geoecology of the Mongolian Academy of Sciences, along with the MJGG Editorial Board, has focused on enhancing the journal's quality and importance, aiming to establish it as an international academic journal. In 2017, the journal transitioned from a printed format to an electronic version (www.mjgg.igg.ac.mn), and in 2019, it received an ISSN number. Furthermore, the journal is officially registered in "Mongolia Journals Online," and each article has been published with a DOI number since 2022. The journal is also indexed in Google Scholar and Dimensions systems, increasing the visibility of authors' articles at the international level and expected to boost citations of published articles, reflecting researchers' academic performances on online evaluation platforms such as ResearchGate and ORCID.

This year, in order to further improve the quality of the journal and to distribute it to international readers, some articles have been accepted in English. In total, 31 articles were received for the 45th issue of the MJGG. Among them, 20 articles that passed the peer-review process and met the journal's criteria are published and presented to our readers and scientists. I would like to express my heartfelt gratitude, both personally and on behalf of the editorial board, to all the academics who contributed their research articles and to the editors who diligently reviewed them for this issue of the journal, which serves as the flagship publication of the Institute of Geography and Geoecology

Let us spread a wealth of knowledge

**Dr. A.Dashtseren, Editor-in-chief, Director,
Institute of Geography and Geoecology**

<https://doi.org/10.5564/mjgg.v61i45.3753>